

Та мэдэх үү?

Тэмбүү нь танд болон урагт аюултай ноцтой халдвар юм.

Хэрэв та жирэмсэн эсвэл удахгүй жирэмслэхээр төлөвлөж байгаа бол урагт халдвар дамжуулахаас сэргийлэхийн тулд аль болох эрт шинжилгээ өгөх нь маш чухал.



Тэмбүү нь бэлгийн замаар дамжих халдвар /БЗДХ/ бөгөөд бэлгийн хавьтлын үеэр халдвартай хүнээс нөгөөд халдварлана. 15-44 насны эмэгтэйчүүдийн дундах тархалт ихэссээр байна. Та өөрийгөө болон дотны хүмүүсээ хэрхэн хамгаалах талаар мэдээлэл эндээс аваарай.



Танд ямар ч шинж тэмдэг илрэхгүй байж болно

Зарим хүмүүс ямар ч зовиургүй, халдвар авснаа мэдэлгүй явах тохиолдол байдаг.

Тиймээс яр шархлаа гарч эхлэх, түүралт үүсэх, булчин үе мөч өвдөж хөндүүрлэх, толгой өвдөх, ядарч сульдах зэрэг шинж илэрч байгаа эсэхийг ажиглаарай.



Шинжилгээ тогтмол өгөх

Тэмбүүгийн сорил нь жирэмсэн үед авдаг чухал шинжилгээнүүдийн нэг. Эмч, эх баригч ба жирэмсний хяналтын эмнэлэгтээ хандан шинжилгээ өгөөрэй.

Шинжилгээ өгөхөд ичих хэрэггүй – хурдан, амархан хийгддэг бөгөөд хувийн нууцыг чандлан хадгална.



Эмчилгээ

Тэмбүүг эмчлэх хялбар – тохирох эмийн бэлдмэлийг хэрэглэхэд халдвар устгах бөгөөд танд болон урагт аюулгүй.

Эмчилгээ хийлгэхгүй бол тэмбүү таны болон хүүхдийн тань эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.



Урьдчилан сэргийлэх

Аюулгүй бэлгийн харилцааг эрхэмлэх - Шинэ бэлгийн хамтрагчтай болохдоо үргэлж бэлгэвч хэрэглэж, тогтмол шинжилгээ өгч хэвшээрэй. Тэмбүүгийн халдварыг бусдад болон танд буцаан халдаахаас сэргийлэхийн тулд бэлгийн хамтрагч тань мөн адил тогтмол шинжилгээ өгөх нь зүйтэй.

Хэрэв бэлгийн хамтрагчтайгаа холбоо барин, энэ талаар мэдээлэхэд таагүй байгаа бол www.letthemknow.org.au вэбсайт руу хандах юм уу эмчтэйгээ ярилцан зөвлөгөө аваарай.



QR кодыг уншуулж тэмбүү болон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг аваарай.